



## GLENVIEW SCHOOL DISTRICT 34

1401 Greenwood Road  
Glenview, Illinois 60026  
[www.glenview34.org](http://www.glenview34.org)

Хүндэт Эцэг Эхэд,

Иллинойс мужийн хуулийн дагуу Glenview 34-р Дүүргийн сургуульд ороход дараахь баримт бичгүүдийг бүрдүүлсэн байх ёстой гэж заасан байдаг. Үүнд:

**Дүүргийн сургуульд анх удаа орж байгаа МӨН сургуулийн бэлтгэл К- анги, 6 -р ангид ороход:**  
Биеийн Ерөнхий үзлэг (нэг жилийн хугацаатай) Дархлаажуулалтын бүртгэл хийсэн баримт

**Дүүргийн сургуулийн бэлтгэл К-анги ЭСВЭЛ түүнээс дээш ангиудад анхлан суралцахад:**  
Тухайн хичээлийн жилийн 10-р сарын 15-наас өмнө Нүдний эмчид үзүүлсэн байх (12 сар доторхи хугацаанд хүчинтэй байх)

**Бэлтгэл К-анги, 2, 6-р ангийн сурагчдын хувьд:**  
Тухайн хичээлийн жилийн 5-р сарын 15-наас өмнө шүдний эмчид үзүүлсэн байх (18 сар доторхи хугацаанд хүчинтэй байх)

Хэрэв хүүхэд нүд, шүдний эмчид үзүүлсэн тухай нотлох баримтыг дээрх хугацаанд ирүүлээгүй тохиолдолд сургууль хүүхдийн улирлын дүнгийн хуудсыг дараахь тохиолдлуудын аль нэгийг (хэрэв боломжтой бол түүнээс дээш) хүлээн автал илгээхгүй байх:

- хүүхэд эмчийн үзлэгт орсон тухай баримт ирүүлэх
- хүүхэд 10-р сарын 15-наас хойш 60 хоногийн дотор нүдний эмчид үзүүлэх тухай нотлох баримт
- хүүхэд 5-р сарын 15-наас хойш 60 хоногийн дотор шүдний эмчид үзүүлэх тухай нотолгоо
- хүүхэд шүд, нүдний шинжилгээнд хамрагдахаас татгалзсан тухай баримт
- хүүхэд шашин шүтлэгийн байдлаар чөлөөлөгдсөн тухай баримт

**Эмчээр бөглүүлэх биеийн ерөнхий үзлэгийн маягтыг энд хавсаргасан байна. Энэхүү маягтыг сургууль эхлэхийн өмнө болон эхний өдрөөс өмнө зохих хэсгүүдийг бөглөн, огноог бичин сургуулийн оффис дээр өгсөн байх ёстой. Биеийн ерөнхий үзлэгийн маягтыг ирүүлээгүй тохиолдолд таны хүүхэд сургуульд орох боломжгүй. Нүд ба шүдний эмчийн үзлэгийн маягтыг энэхүү захианд мөн хавсаргасан байна.**

34-р Дүүрэг нь Ronald McDonald House эмнэлэгтэй хамтран биеийн ерөнхий үзлэг, дархлаажуулалт хийхэд санхүүгийн тусламж шаардлагатай хүүхдүүдэд зориулан ажиллаж байна. Сургуулийнхаа эрүүл мэндийн зохицуулагчтай холбогдож энэ талаарх нэмэлт мэдээллийг авна уу.

34-р Дүүрэг мөн санхүүгийн тусламж шаардлагатай хүүхдүүдэд зориулан Smile Illinois шүдний эмчийн үзлэг хийлгэхээр хамтран ажилладаг. Сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн зохицуулагчтай холбогдож санхүүгийн тусламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлийг авна уу.

Таны хүүхдийн эрүүл мэнд бидний хувьд их ач холбогдолтой ба сургуульд орж суралцахад чухал хүчин зүйл болдог. Энэхүү мэдээллийн талаар асуух зүйл байвал сургуулийнхаа оффисруу холбогдоно уу.

Хамтран ажиллаж байгаад баярлалаа.

Хүндэтгэсэн:

Dane Delli, Ph.D.  
Тэргүүн Удирдагч

Тэмдэглэл:

Cook Count-ийн дархлаажуулалтыг үнэгүй хийдэг эмнэлгийн жагсаалтыг сургуулийнхаа эрүүл мэндийн албанаас авна уу.